



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/244/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Цэрэнханд Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn Аудитор: С.Санчирмаа Утас: 99282488 Цахим хаяг: sanchirmaas@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024. 02. 22 № 52

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Говь-Алтай аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 29,999.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан. Цаг уур, орчны шинжилгээний газраас 38,107.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шилжүүлсэн авсан байна.

Аудитын гол асуудал

Улсын төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 621,471.0 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын цалин, хөлс нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 13 зорилт, 40 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 4 арга хэмжээг 99.2 хувь, 36 арга хэмжээг 90.0 хувь буюу нийт дүнгээр 98.3 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд Цаг, уур орчны шинжилгээний газраас 89.2 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль,

0702900222

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	251,898.1	259,764.1
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	808,662.9	815,245.8
	Нийт хөрөнгийн дүн	1,060,561.0	1,075,009.9
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,060,561.0	1,075,009.9
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,060,561.0	1,075,009.9
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,551,745.3	2,055,067.6
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,379,000.0	1,920,966.7
	Үйл ажиллагааны үр дүн	172,745.4	134,100.9
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	119,652.0
	Үйл ажиллагааны нийт үр дүн	172,745.4	14,448.9
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	887,815.6	1,060,561.0
	Тайлант оны үр дүн	172,745.4	14,448.9
	Эцсийн үлдэгдэл	1,060,561.0	1,075,009.9
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,257,605.7	1,869,031.5
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,257,255.7	1,839,032.5
	Үйл ажиллагааны ЦМГ	350.0	29,999.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(350.0)	(29,999.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,856,731.6	1,852,012.2
	Урсгал зардал	1,856,731.6	1,852,012.2
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,856,731.6	1,852,012.2
	Улсын төсвөөс санхүүжих	1,856,131.6	1,847,112.3
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	600.0	4,899.9

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар 4,630.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгийн биет бус хөрөнгийг 4,630.0 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 13,055.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 13,055.8 мянган төгрөгийн 4 зөрчил² илэрснээс 3 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлсэн.

Албан шаардлага

1. Илүү цагийн хөлсийг түүвэрлэн цагийн бүртгэлтэй тулган баталгаажуулахад 289.1 мянган төгрөгөөр илүү, 248.1 мянган төгрөгийн дутуу тооцож олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1-т "Илүү цагаар ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүний дундаж цалин хөлсийг нэг аравны тав дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлж олгоно" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 1. Илүү цагийн хөлсийг журмын дагуу тооцоолж байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Даатгуулагчаас төлөх нийгмийн даатгалын шимтгэл 1,025.8 мянган төгрөгийг ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас төлж эдийн засгийн ангилал зөрчсөн нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалтай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг ангиллын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд нэг албан хаагчийн 591.4 мянган төгрөгийн цалинг дутуу тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах"; Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалд дутуу тайлагнасан албан хаагчийн цалинг нөхөн тайлагнах албан шаардлага хүргүүлсэн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант онд 12 албан хаагчид албан тушаалын тодорхойлолтод заасан 9,090.2 мянган төгрөгийн, 1 албан хаагчид хяналт тавих чиг үүргийн албан тушаалын

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хавсарсан 2,348.4 мянган төгрөгийн хавсран ажилласан нэмэгдэл олгосон нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална: 4.1.3.үр ашигтай байх; Төсвийн тухай хуулийн 6.4-т Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хууль эрх зүйн хүрээнд хавсран ажилласан нэмэгдэл олгож байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/												
Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Говь-Алтай аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээн ий төв	1	4.6	1	4.6	-	-	1	4.6	-	-	-	-
Дүн	1	4.6	1	4.6	-	-	1	4.6	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Говь-Алтай аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төв	4	13.0	-	-	3	1.6	1	11.4	-	-	-	-
Дүн	4	13.0	-	-	3	1.6	1	11.4	-	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10